



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,  
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2021.01.28 № 01/387  
танай 2021-01-20-ны № 02 -т

Улсын Их Хурлын гишүүн Танаас 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн асуултад дараах хариултыг хүргүүлж байна.

1. Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн чуулганд зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын талаар мэдээлэл хийх үеэр Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс 2020 оны 10 дугаар сарын 30,31 болон 11 дүгээр сарын 01, 06-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт тус тус зохион байгуулагдсан төмөр замчдын спортын болон ур чадварын тэмцээн уралдаанд гадны зочид төлөөлөгчид, нэн ялангуяа ОХУ-аас төмөр замчид ирж оролцсоноос төмөр зам дагуу короновируст халдвар тархсан эсэх талаар асуулга тавьж, мөн Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан дээрх асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шалгуулж, тогтоолгохыг үүрэг болгосон. Үүнтэй холбогдуулан Дархан-Уул аймагт төмөр замчдын дунд уралдаан, тэмцээн зохион байгуулах үеэр ОХУ-ын иргэд оролцсон эсэхийг шалган тогтоож өгөхийг хүссэн тухай 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/5841 дугаар албан бичгээр Тагнуулын ерөнхий, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газруудад тус тус хандсан бөгөөд Тагнуулын ерөнхий газраас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 1688 албан бичгээр ОХУ-аас хүмүүс ирж оролцоогүй тухай, мөн Цагдаагийн Ерөнхий газраас 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/67 дугаар албан бичгээр Дархан өртөөнд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд ОХУ-аас болон “УБТЗ” ХНН-ийн орос ажилтан, мэргэжилтэн нараас оролцоогүй болох нь тус тус тогтоосон бөгөөд мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлж явуулж байгаа тухай, Хил хамгаалах ерөнхий газраас 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/9918 дугаар албан бичгээр соёл, урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээнд оролцохоор ОХУ-ын иргэд Монгол улсад зорчоогүй тухай хариуг тус тус ирүүлээд байна.

2. “УБТЗ” ХНН-ээс Дархан-Уул аймагт 2020 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан “Тээвэр зохион байгуулалтын аварга шалгаруулах спортын тэмцээн”, 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр “Ээлжийн нэгдсэн бригадын ур чадварын тэмцээн”-д Оросын Холбооны Улсаас болон Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгт ажилладаг Оросын Холбооны Улсын харьяат ажилтан, алба хаагчид оролцоогүй болох нь тус тус тогтоогдсон.

3. “УБТЗ” ХНН нь Төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжилтэнг оруулж ирэхдээ Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 164 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ОХУ-аас нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах хүчийг ажиллуулахдаа халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан, хууль, тогтоомжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



- Орос мэргэжилтнүүдийг оруулж ирэх бэлтгэл ажлын хүрээнд 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс халдвар хамгааллын дэглэм баримтлах төлөвлөгөө гаргаж УОК-ын Шуурхай штабаар хянуулан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал Г.Ариунбуянаар батлуулсан.

- Тухайн төлөвлөгөөний дагуу УОК-ын Шуурхай Штабын хяналтын баг “Ган зам” зочид буудлыг тусгаарлах байрны шаардлагад нийцэж буй эсэхэд үзлэг шалгалт хийж, заавар зөвлөмж өгч тусгаарлах байрны шаардлагад нийцнэ гэж зөвшөөрсөн.

- ОБЕГ-ын мэргэжилтэн, ХӨСҮТ-ийн эмч нар 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тус тусгаарлах байранд ажиллах бүрэлдэхүүн болон Орос мэргэжилтнүүдийг тээвэрлэх үеийн халдвар хамгааллын талаарх сургалтыг зохион байгуулсан.

- Төлөвлөгөөний дагуу тус мэргэжилтнүүдийг 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр том оврын автобус, цагдаагийн хамгаалалттай, халдваргүйжүүлэх багийн эмнэлгийн тусгай зориулалтын машинтай тээвэрлэх зааварчилгаа өгч Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор нэвтрүүлэн 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, хот хооронд тээвэрлэж, “Ган зам” зочид буудалд ОХУ-ын 30 иргэн, /үүнд: Улаанбаатар төмөр замд ажиллах 24 хүн, “УБТЗ” ХНН-ийн гадаад мэргэжилтэн 3 хүн, тэдгээрийн гэр бүлийн 3 хүн/ жолооч 1 хүнийг тусгаарласан.

- Тусгаарлах байранд Онцгой байдлын хяналтын ажилтан, Цагдаагийн алба хаагч болон хамгаалалтын алба хаагч болон төмөр замын 2 эмч, 2 үйлчлэгч ажилласан.

- Тусгаарлалтын 21 хоногийн хугацаанд 2020 оны 09 дүгээр сарын 08, 19, 23-ны өдрүүдэд PCR шинжилгээг авсан бөгөөд хариу сөрөг гарсан.

- Эрүүл мэндийн яамны зөвлөмж болон УОК-ын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2584 тоот албан бичгээр “Ган зам” зочид буудалд тусгаарласан иргэдийг тусгаарлалтаас гаргах зөвшөөрөл авсны дагуу тусгаарлалтаас гаргаж 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр тусгай галт тэргээр Замын-Үүд өртөөнд, 2020 оны 10 дугаар сарын 08-наас 26-ны өдрүүдэд Замын-Үүд, Шаргын-Овоо өртөөдөд их засварын ажил, 2020 оны 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл Баян зөрлөгийн замын өргөтгөлийн их засварын ажлуудыг тус тус гүйцэтгэсэн бөгөөд тусгай вагонд байрлуулсан болно.

- Байрлаж байсан галт тэрэгтэйгээ 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатараас Сүхбаатар өртөөнд хүрч 11 дүгээр сарын 07-ны 22:00 цагийн үед тусгай автобус гаргаж Алтанбулаг боомтоор 20 мэргэжилтнүүдийг ОХУ руу буцаасан. Үлдсэн 4 мэргэжилтэн нь 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Алтанбулаг боомтоор ОХУ руу буцсан.

ОХУ-аас ирсэн мэргэжилтнүүд нь батлагдсан төлөвлөгөөнд тусгаснаар ажлын нягт хуваарийн дагуу ажиллаж байгаад нутаг буцаасан бөгөөд Дархан өртөөнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд оролцоогүй болно.

Хавсралт: <sup>10</sup> хуудастай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ХАЛТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ГИШҮҮН, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Л.ХАЛТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,  
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2021.01.19 № 01/67

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Танилцуулга хүргүүлэх тухай**

Таны 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/5841 дүгээр албан бичгээр цагдаагийн байгууллагад хандсан “Төмөр замчдын тэмцээний үед ганц нэг Оросын Холбооны Улсын иргэд байсан. Тэр хүмүүс бол тухайн үед шинжилгээтэй байсан учраас тэндээс халдвар орж ирсэн гэж бид хэлэхгүй гэх мэдээллийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт, судалгааны албаны дарга А.Амбасэлмаа өгсөн. Мөн Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс энэ талаар асуулга тавьсан. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан дээрх асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шалгуулж, тогтоолгохыг үүрэг болгосон. Иймд дээр дурдсан асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нэн даруй шалгаж, бидний ажилд тусална уу” гэх хүсэлтийг гомдол, мэдээллийн Г-573 дугаарт бүртгэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Дээрх гомдол, мэдээлэлд дурдагдсан Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны албаны дарга А.Амбасэлмаа, Өдрийн сонины сэтгүүлч сурвалжлагч С.Лхамсүрэн нараас гэрчээр мэдүүлэг авч, Эрүүл мэндийн яамны энэ оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 11.00 цагийн “Коронавируст халдвар /КОВИД-19/ -ын нөхцөл байдал”-ын хэвлэлийн бага хурлын бичлэгт үзлэг хийн, тэмдэглэл үйлдэж, мөн оны 12 дугаар сарын 24-ний өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасны дагуу харьяаллын дагуу шилжүүлэх саналтай Нийслэлийн прокурорын газарт хүргүүлжээ.

Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурорын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор гомдол, мэдээллийг шалгах харьяаллыг Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газарт, хяналт тавих харьяаллыг тус аймгийн Прокурорын газарт тогтоосон бөгөөд тус аймаг дахь цагдаагийн газар 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүлээн авч, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэлтийн 211800023 дугаартай хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

Дархан-Уул аймгийн Төмөр замын Дархан-Өртөө байгуулагдсаны 70 жилийн ойд зориулж төмөр замчдын дунд “Мэргэжлийн ур чадварын аварга шалгаруулах 2020” тэмцээнийг энэ оны 11 дүгээр сарын 06-ны өдөр тус аймгийн Дархан сумын 4 дүгээр багт байрлах Төмөр замын өртөө, Дархан сумын 14 дүгээр багт байрлах Спортын ордонд тус тус зохион байгуулсан.

Тус тэмцээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Улаанбаатар хотын Толгойт, Дорноговь аймгийн Замын-Үүд зангилаанаас тус бүр 13, Зүүнхараа, Дархан-Уул аймгийн Дархан, Багануур дүүргийн Багануур, Дорноговь аймгийн Сайншанд зангилаанаас тус бүр 11, Улаанбаатар, Говьсүмбэр аймгийн Чойр зангилаанаас тус

0900379

бүр 12, Орхон аймгийн Эрдэнэт зангилаанаас 14 нийт 135 ажилтан, алба хаагч оролцож, шагнал гардуулах ажиллагаа тус аймгийн Өргөө кино театрт болсон.

Тэмцээнд Оросын Холбооны Улсаас болон Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгт ажилладаг Оросын Холбооны Улсын харьяат ажилтан, алба хаагчид оролцоогүй болох нь тус тус тогтоогдсон бөгөөд мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байгааг танилцуулъя.

Хүндэтгэсэн

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА



Ж.БОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Жуулчны гудамж-3, Утас: 9226 3656, 9226 3017,  
Факс: 9226 3656, Вэб хаяг: <http://www.gla.gov.mn>,  
И-мэйл: [info@gla.gov.mn](mailto:info@gla.gov.mn)

2020.12.11 № 1888

Танай 2020.12.05-ны № 01/5841-г

Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН Г  
САЙД Л.ХАЛГАР ТАНАА Г

“УБТЗ” ХНН-ээс Дархан-Уул аймагт 2020 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан “Тээвэр зохион байгуулалтын аварга шалгаруулах спортын тэмцээн”, 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр “Ээлжийн нэгдсэн бригадын ур чадварын тэмцээн”-д “ОХУ-аас дарга нар, холбогдох хүмүүс ирж оролцсон” гэх мэдээллийг шалгахад ОХУ-аас холбогдох хүмүүс ирж оролцоогүй болох нь тогтоогдсон болно.

ДАРГА  ГОДОНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР**

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Б.Доржийн гудамж, Утас: 26-66-38, Факс: (976-51) 26-41-43  
E-mail: border\_pgb@bpo.gov.mn, http://bpo.gov.mn

2020.11.08 № 119918  
танай 2020.12.05 -ны № 01/5841 -т

**Хариу хүргүүлэх тухай**

Монгол, Оросын хилийн авто замын боомтуудаар нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн зогсоосноос хойш ОХУ-аас ирсэн зорчигчдыг зөвхөн Улсын онцгой комиссын шийдвэрээр хилийн "Алтанбулаг" боомтоор хил нэвтрүүлж байна.

Дээрх хугацаанд "Улаанбаатар төмөр зам" Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн шугамаар соёл, урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээнд оролцохоор ОХУ-ын иргэд Монгол Улсад зорчоогүй бөгөөд дараах иргэдийг зохих зөвшөөрлийн дагуу улсын хилээр нэвтрүүлсэн. Үүнд:

1. Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 98 дугаар албан бичгээр олгосон зөвшөөрлийг үндэслэн УБТЗ-ын ачааны хөдөлгөөнд ашиглах илчит галт тэргийг ОХУ-ын Брянск хотоос Улаанбаатар хот руу хүргэх, засварлах зорилгоор ирсэн тус улсын 3 иргэнийг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, 2 иргэнийг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр;

2. Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 239 дүгээр албан бичгээр олгосон зөвшөөрлийг үндэслэн УБТЗ-ын Суурь бүтэц хариуцсан замын орлогч дарга ОХУ-ын 1 иргэнийг 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр;

3. Улсын онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 2192 дугаар албан бичгээр олгосон зөвшөөрлийг үндэслэн Засгийн газрын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 2020 оны 164 дүгээр тогтоолын хавсралтад заагдсан "УБТЗ" ХНН-ийн хэрэгжүүлж буй төслийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажил гүйцэтгэх ОХУ-ын 28, Украин Улсын 2 иргэнийг 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр тус тус улсын хилээр нэвтрүүлсэн болно.


Дархан-Уул аймагт 2020 оны 10 дугаар сарын 30, 31, 11 дүгээр сарын 01, 06-ны өдрүүдэд болсон төмөр замчдын спортын болон ур чадварын тэмцээн уралдаанд ОХУ-аас төмөр замчид ирж оролцсоны улмаас коронавируст халдвар тархсан, эсэх асуудлыг шалгуулж, тогтоолгох асуудлаар холбогдох байгууллагад хандана уу.

“УБТЗ” ХНН-ийн шугамаар Монгол Улсад ирсэн гадаадын иргэдийн мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт *2* хуудастай.


Хүндэтгэсэн,

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Ж.БЯМБАСҮРЭН

Хил хамгаалах зөрөнхий газрын 2020 оны 03 дугаар сарын 03 ны өдрийн дугаар албан бичгийн хавсралт



АЛТАНБУЛАГ ХИЛИЙН БООМТООР "УБТЗ" ХНН-ИЙН ШУГАМААР МОНГОЛ УЛСАМ ИРСЭН ГАДААДЫН ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

д/д	Овог, нэр	Паспортын дугаар	Харьяалах улс	Хил нэвтэрсэн он, сар, өдөр	УОК-ын зөвшөөрлийн огноо, дугаар	Захиалагч байгууллага
03 дугаар сар						
1	Beliakov Dmitrii	754596682	ОХУ	2020.03.16	2020.03.14 №98	"УБТЗ" ХНН /УБТЗ-ын ачааны хөдөлгөөнд ашиглах илчит галт тэргийг ОХУ-ын Брянск хотоос Улаанбаатар хот руу хүргэж, засварлах/ 5 ажилтан
2	Prazdnikoy Ivan	761721554	ОХУ			
3	Shugarov Evgenii	759311627	ОХУ			
4	Kazakov Dmitrii	731250903	ОХУ			
5	Annaorazov Rustam	731777057	ОХУ	2020.03.15		
6	Belosh Konstantin	759770595	ОХУ	2020.03.26	2020.03.26 №239	"УБТЗ" ХНН /УБТЗ-ын Суурь бүтэц хариуцсан замын орлогч дарга/
09 дүгээр сар						
7	Borovikov Alexander	717416897	ОХУ	2020.09.05	2020.09.01 №2192	ЗГ-ын 2020 оны 164 дүгээр тогтоолын хавсралтад заагдсан Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцох "УБТЗ" ХНН-ийн гадаадын инженер, техникийн 30 ажилтан
8	Bedunkov Vladislav	731094837	ОХУ			
9	Rudkin Sergei	660348538	ОХУ			
10	Mikhailov Andrei	661055747	ОХУ			
11	Gorbunov Mykhailo	FG601220	Украйн			
12	Krasikov Viacheslav	660348501	ОХУ			
13	Pen Evgenii	661055748	ОХУ			
14	Grebenkov Evgenii	761959871	ОХУ			
15	Pirozhkov Vladimir	756309197	ОХУ			
16	Shishkov Aleksandr	757950439	ОХУ			
17	Davydenko Igor	716705190	ОХУ			
18	Gorbunova Iryna	FG601227	Украйн			
19	Evtexhov Artur	660348547	ОХУ			
20	Belosh Olga	753756665	ОХУ			
21	Biankin Evgenii	660348536	ОХУ			
22	Mordovskoi Aleksandr	660348541	ОХУ			
23	Pavlovskii Viacheslav	660348544	ОХУ			
24	Makarov Iurii	752399230	ОХУ			
25	Solodkii Andrei	730509829	ОХУ			



26	Kutsyi Viktor	736130561	OXY			
27	Sinitsyn Vladimir	660348542	OXY			
28	Chernov Andrei	763283626	OXY			
29	Kanaev Iurii	660348539	OXY			
30	Pavlov Sergei	660348520	OXY			
31	Stupin Sergei	660348546	OXY			
32	Sinitsyn Vladimir	660348543	OXY			
33	Arshinskii Igor	660348540	OXY			
34	Shashin Vladimir	736312727	OXY			
35	Bobko Aleksandr	757933775	OXY			
36	Anisimov Dmitrii	750538671	OXY			

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улсын Засгийн газрын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 2019 оны 420, 2020 оны 164 дүгээр тогтоол, Улсын Онцгой Комиссын 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн боловсруулав.

**МОНГОЛ УЛСЫН ХИЙГЭЭР "ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН  
414.6 КМ ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" ТӨСӨЛ, "РАДИО СУВГААР  
ГАЛТ ТЭРЭГНИЙ ХОДОЛГӨӨНИЙ ХООРОНДЫН ЗАЙ, ХУГАЦААГААР  
ЗОХИЦУУЛАХ СИСТЕМ (СИРДП-Е)" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАДААДЫН  
АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ НЭВТРҮҮЛЭГЧ, ТУСГААРЛАХ ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 оны . . сарын ... өдөр

Улаанбаатар хот

"Улаанбаатар төмөр зам" ХНН нь 2015 оноос эхлэн "Радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөний хоорондын зай, хугацаагаар зохицуулах систем (СИРДП-Е)" нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд Засгийн газрын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 2019 оны 420 дугаар тогтоолын дагуу гадаадын 17 ажилтан (ОХУ-ын 14, БНХАУ-ын 3), Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын барилгын ажилд зориулан Засгийн газрын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай" 2020 оны 164 дүгээр тогтоолын дагуу гадаадын 20 ажилтан (ОХУ-ын 20) авч ажиллуулна

Эдгээр төслүүдэд ажиллах ОХУ-ын нийт 34 инженер техникийн ажилтанг Монгол Улсын хилээр 2020 оны 09 дугаар сарын 05-ны өдөр нэвтрүүлж, Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комиссын шуурхай штабаас "COVID 19" цар тахлаас урьдчилан сэргийлэх Мэргэжлийн баг хяналт тавин ажиллаж, гадаад ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулах, тусгаарлан ажиглах байранд байрлуулж харуул хамгаалалтыг зохион байгуулах, зөвлөмж чиглэлийн дагуу дэг журмыг чанд мөрдүүлэх, төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэх ба БНХАУ-ын 3 ажилтанг Замын-Үүд боомтоор Монгол Улсын иргэдийн нэгдсэн зохион байгуулалтаар татан авах ажиллагаанд хамруулна. Үүнд:

№	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Гүйцэтгэх байгууллага
<b>Нэг. Бэлтгэл ажлын хүрээнд</b>			
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хандаж гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах	08/24 08/28	НХХЯ-ны ХХҮЕГ
2	Гадаадын иргэн харьяатын газарт хандаж визийн асуудлыг шийдвэрлэх	09/01 09/03	ГИХГ
3	Гадаад харилцааны яамнаас гадаад иргэдийг хилээр оруулах тухай дэмжлэг хүсэх	09/01	ГХЯ
4	ОХУ-ын Эрхүү хотод суугаа Ерөнхий Консулын газарт мэдэгдэж, оросын талаас хилээр нэвтрүүлэхэд дэмжлэг хүсэх	09/02	ГХЯ
5	Гадаад ажиллах хүчийг татан авах, тусгаарлах байр, хоол, шатахуун, тээвэр, бусад төрлийн шаардагдах зардлын тооцоо гарган шийдвэрлэх	Тухайн үед нь	"УБТЗ" ХНН
6	Коронавируст халдвар (COVID 19)-ын үед иргэдийг тусгаарлах, ажиглах түр журмын	07/03	ХӨСҮТ

	хүрээнд халдваргүйжүүлэлтийг хийж, аюулгүй бүсийг тогтоож, мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах	(Ганзам зочид буудалд зохион байгуулагдсан)	
7	ОБЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/80 дугаар тушаалаар батлагдсан "Ажиглах байрыг сонгох, бэлтгэлийг хангуулах удирдамж"-ийн дагуу тусгаарлах байрыг бэлтгэж, хяналт тавих, байранд үзлэг шалгалт хийх (хийгдсэн)	07/02 (Ганзам зочид буудлыг шалгаж үзлэг шалгалт хийсэн)	УОК-ын Шуурхай штабын ажлын хэсэг
<b>Хоёр. Тусгаарлах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>			
1	Ажиллах хүч нь Монгол Улсын хилээр нэвтрэхээс 48 цагийн өмнө ОХУ-д коронавирусийн шинжилгээ өгсөн байна.	09/02 09/03	"УБТЗ" ХНН
2	Гадаад ажилчдыг 2020 оны 09 дугаар сарын 05-ны өдөр Алтанбулаг хилийн боомтоор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	09/05	ГХЯ ХХЕГ
3	Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаад ажилчдыг "COVID 19" шинжилгээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамруулж /3-аас доошгүй удаа/, шинжилгээний хариуг авч, мэдээлэх	09/05 09/26	ЭМЯ ХӨСҮТ
4	Алтанбулаг хилийн боомтоос автобусаар Улаанбаатар хот дахь "Ганзам" зочид буудал хүртэл тээвэрлэх ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	09/05	ЦЕГ, Аймгийн онцгой комисс, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс
5	Татан авсан инженер техникийн ажилтнуудыг зохион байгуулалттайгаар урьдчилсан товлосон байрлалд түр зогсолт хийлгэх үед ариутгал халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах	09/05	Орон нутгийн мэргэжлийн байгууллага, Тээврийн цагдаагийн алба, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс
6	Тээвэрлэгч жолоочид сургалт зохион байгуулах	07/03 (зохион байгуулагдсан)	ХӨСҮТ, УБТЗ-ын Төв эмнэлэг, ТЦА, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс
7	Тээвэрлэн ирсэн автобусанд ариутгал халдваргүйжүүлэлт хийх	09/05	ЗӨСҮТ, "УБТЗ" ХНН

8	Гадаад ажилчдыг "Ганзам" зочид буудалд байрлуулах ажлыг Шуурхай штабтай хамтран зохион байгуулах	09/05	Шуурхай штаб, "УБТЗ" ХНН
9	"Ганзам" зочид буудлыг ажиглалт, хяналтад авах үед эрүүл мэнд, онцгой байдлын алба, цагдаагийн байгууллага хамгаалалтыг зохион байгуулах, эдгээр байгууллагуудаас шаардагдах зардлыг "УБТЗ" ХНН хариуцах	Тухайн үед нь	МХЕГ ОБЕГ ЦЕГ УБТЗ-ын Төв эмнэлэг Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс
10	Ажиглалтад байх явцад шинжилгээ авах, харуул хамгаалалт, хяналтын үзлэг шалгалтыг 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/343 тоот "Тусгаарлах, эмчлэх, ажиглах байрны бэлэн байдал хангах тухай" журмын дагуу хангасан байх	09/03	Шуурхай штаб, "УБТЗ" ХНН
11	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлын мэдээллийг "УБТЗ" ХНН-ийн Гамшгаас хамгаалах штабын дарга Ч.Цогтбаяр хариуцаж Улсын онцгой комиссын Шуурхай штабд мэдээлнэ.	08/24 09/26	"УБТЗ" ХНН
12	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц нөхцөл байдалд Улсын Онцгой комиссын шуурхай штаб хяналт тавьж ажиллана.	08/24 09/26	Улсын онцгой комиссын Шуурхай штаб
13	Ажлын төлөвлөгөөний хүрээнд гарах бүх зардлыг "УБТЗ" ХНН хариуцна.	Тухайн үед нь	"УБТЗ" ХНН

**ЗӨВШӨӨРСӨН:**

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

ОБЕГ-ЫН ДЭД ДАРГА, ШУУРХАЙ  
ШТАБЫН ДАРГА, ХУРАНДАА

Б.УУГАНБАЯР

ЦЕГ-ЫН ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.АМГАЛАН

ЭМЯ-НЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ЧАНАР  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ө.ЖАРГАЛСАЙХАН

ХХҮЕГ-ЫН ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ,  
МЭРГЭЖИЛТЭН АВАХ ХЭЛТСИЙН ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

НМХГ-ЫН ЭРҮҮЛ АХУЙН ХАЛДВАР, ХАМГААЛЛЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БОЛОРМАА

МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН  
"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ"  
НИЙГЭМЛЭГИЙН ДАРГА

Д.ЖИГЖИДНЯМАА